



ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 5 ЖИЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2016 он)

2011 оны 10 дугаар сарын 6



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С. ЛАМБАА

Стратеги төлөвлөгөөг боловсруулсан ажлын хэсэг:

№	НЭРС	АЛБАН ТУШААЛ
1	Л. Төмөрбаатар	Ерөнхий захирал
2	О. Баяр	Стратегитөлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал, ажлын хэсгийн ахлагч
3	Г. Навчаа	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
4	Г. Пүрэвсүрэн	Эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирал
5	Ц. Туул	ЭШСМАлбаны эпидемиологич, их эмч, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
6	Д. Мөнхтуяа	Хүний нөөцийн албаны дарга
7	Д. Алтанцэцэг	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга
8	Д. Дуламсүрэн	Сувилахуйн албаны дарга
9	Д. Эрдэнэцэцэг	Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх албаны дарга
10	Ч. Мөнхзаяа	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны менежер
11	Д. Наран	Мэс заслын клиникийн зохицуулагч
12	Б. Анхзаяа	Мэс заслын бус клиникийн зохицуулагч
13	Т. Ундармаа	ЭШСМАлбаны эпидемиологич, их эмч
14	Д. Лхагвасүрэн	Эдийн засагч
15	Д. Дуламсүрэн	Их эмч нарын төгсөлтийн дараах сургалтын арга зүйч

ТОВЧЛОЛ

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДЭМН	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл
ЗГХА-ЭМГ	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрүүл мэндийн газар
ЗҮӨХ	Зан үйлийг өөрчлөх харилцаа
ЗХУ	Зөвлөлт холбоот улс (хуучнаар)
МСС	Мэдээлэл, сургалт сурталчилгаа
ОУАЭА	Олон улсын атомын энергийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

I. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний хавдар судлалын албаны хөгжлийн товч тойм

Эрүүл мэндийн салбар үүсч, хөгжсөн замнал, үүний дотор хорт хавдрыг эмчилэн хянаж байсан өмнөх ба одоо үеийн байдал, зарим эмч, эрдэмтдийн бичиж хэвлүүлсэн материалд тулгуурлан хавдар судлалын албаны хөгжлийг дөрвөн үе болгон авч үзэж болох юм.

Нэгдүгээр үе (1921-1960)

1921-1960 оныг хамрах энэхүү үед хавдар судлалын бие даасан тусламж бий болох суурь бэлтгэл хангагдсан гэж үзэж болно. Манай улсад эрүүл мэндийн салбар үүсч хөгжиж байх эхэн үед (1921-1940 он) хүн амын дунд бэлгийн замын болон бусад халдварт өвчний тархалт элбэг байсан тул анхаарлын төвд байжээ. Хорт хавдрыг хянах асуудал хорт хавдартай өвчтөнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудлын хүрээнд хязгаарлагдаж байв. Академич Т. Шагдарсүрэнгийн (1960) бичсэнээр, дотор ба эмэгтэйчүүдийн тасагт ажиллаж байсан мэс заслын ганц нэг орыг эс тооцвол 1932 он хүртэл манай улсад мэс заслын бие даасан тусламж, үйлчилгээ байгаагүй байна. 1934 оноос 20 ортой мэс заслын тасаг анх Улаанбаатар хотод, хожим аймгуудад байгуулагдаж, хорт хавдрын эмчилгээний үндсэн хэлбэрийн нэг болох мэс заслын эмчилгээг өнгөц байрлалын зарим эрхтний хавдрын үед цөөн тоогоор хийдэг болжээ. Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ 1940 оноос өргөжиж эхэлсэнтэй холбоотойгоор хавдар өвчний мэс заслын эмчилгээний арга өргөнөөр нэвтэрч, зөвхөн өнгөц төдийгүй гүнд байрлалтай хорт хавдрын үед мэс заслын эмчилгээг амжилттай хийдэг болсон байна.

Хоёрдугаар үе (1961-1982)

1961-1982 онд хорт хавдрын төрөлжсөн тусламж, үйлчилгээг зохион байгуулж эхэлсэн байна. 1961 онд “Цацраг туяа” эмнэлэг байгуулагдсанаар хорт хавдрын төрөлжсөн тусламж, үйлчилгээ үүсч хөгжих эхлэл тавигдсан гэж үздэг. Цацраг туяа эмнэлэг нь анх 45 ортой хэвтүүлэн эмчлэх нэг тасаг, амбулатори, клиник ба эд, эс зүйн лаборатори, эмийн сан, захиргаа аж ахуй гэсэн дөрвөн нэгжтэй, 5 монгол их эмч, хуучнаар Зөвлөлт холбоот улсын 4 мэргэжилтэнтэйгээр байгуулагджээ. Цацраг туяа эмнэлгийн орны тоо 1961-1981 оны хугацаанд 2.4 дахин, их эмчийн тоо 4 дахин нэмэгдэж, улмаар зөвхөн туяа эмчилгээ төдийгүй мэс засал, эмэгтэйчүүдийн болон эмийн (хими) эмчилгээний хэсэгтэй болж өргөжсөн байна.

Гуравдугаар үе (1982-2006)

Цацраг туяа эмнэлэг нь 1982 онд Улсын хавдар судлалын төв болон өргөжиж, зориулалтын шинэ байранд орсноор хавдрын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд, хот хөдөөгийн хүн амд үзүүлэх боломжтой болж өргөжсөн байна. Тухайлбал хэвтэн эмчлүүлэх хэсэг нь тус бүр 60 ортой мэс засал, туяа эмчилгээ, эмэгтэйчүүдийн болон 20 ортой хими эмчилгээний тасгуудын зэрэгцээ хагалгааны хэсэг, сэхээн амьдруулахын 4 ортой тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байжээ. Амбулатори нь тус бүр 6000 кюри идэвхжилтэй Со-

60 үүсгүүр бүхий АГАТ-С, РОКУС-М, АГАТ-В зэрэг туяа эмчилгээний аппарат бүхий эмчилгээний кабинет, эмчилгээний зориулалттай ил ба далд изотопын 8 ортой хэсэг, мөн бөөр, бамбай, элэг, яс, уушигны хавдрыг оношлох кабинеттай цөмийн онош зүйн лаборатори, рентген ба лимфоангиографийн 7 кабинет бүхий рентген оношийн хэсгүүдээс бүрдсэн рентген-радиологийн тасаг, үзлэгийн 7 кабинеттай тус тус ажиллаж байсан байна. Мөн нэгдсэн лаборатори нь биохими, микологи, клиник, бактериологи, иммунологи, цитологи-гистологийн оношилгоог хийх чадамжтай байжээ. Түүнчлэн бүтцэд нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон угаалга, гал тогоо, мөн захиргаа аж ахуй, инженер техникийн зэрэг 10 тасаг ажиллаж байжээ.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг болсноор сургалт, эрдэм шинжилгээний баазын үүргийг давхар гүйцэтгэж эхлэхийн зэрэгцээ 1983 оноос нийт аймаг, дүүрэгт байгуулагдсан хавдар судлалын орон тооны кабинетад арга зүйн дэмжлэг үзүүлдэг болжээ. 1990 оноос компьютерийн томограф, 1991 оноос телевизийн системтэй олон хувилбарт рентген оношийн аппарат, зөөврийн болон суурин ЭХО аппарат, цахим тооцоолуурт стереограф, хагалгааны явцын ба дараах кардиомонитор зэрэг оношлогоо, эмчилгээний олон аппарат ашиглалтанд оров. 1992 онд толгой хүзүүний мэс заслын тасаг, 1999 онд сувилахуйн алба, 2002 онд хөнгөвчлөх эмчилгээний тасаг, 2003 онд эрдэм шинжилгээ, сургалт мэдээллийн албыг тус тус шинээр үүсгэн зохион байгуулснаар эмчилгээ, үйлчилгээ, хавдрын үндэсний бүртгэл мэдээлэл, сургалт судалгааны ажлын хүрээ улам өргөжсөн. 1982-2006 онд эмнэлгийн орны тоо 4.9 дахин, их эмчийн тоо 10 дахин нэмэгджээ.

Дөрөвдүгээр үе (2006-одоог хүртэл)

2006 онд Монгол Улсын хавдар судлалын төвийг Хавдар судлалын үндэсний төв болгон, үйл ажиллагааг нь өргөжүүлсэн байна.

II. ХАВДАР СУДЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хавдар судлалын үндэсний төв

Эрхэм зорилго

Үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч нь байхад оршино.

Байгууллагын тодорхойлолт

Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ) нь Монгол Улсын Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа байгууллага юм. ХСҮТ-ийн дүрэмд зааснаар тус байгууллага нь хүн амын дунд хорт хавдар өвчний тархалтын түвшинг тогтоож, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судалж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, эрдэм шинжилгээ, сургалт, эмнэлгийн үйлчилгээ явуулдаг төрийн үйлчилгээний байгууллага юм.

Үйл ажиллагааны хүрээ

ХСҮТ нь хорт хавдрыг хянах чиглэлээр ажиллаж буй үндэсний гол байгууллага юм. ХСҮТ нь хорт хавдрыг хянах бодлогыг тодорхойлох, үүнд Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний дэд хөтөлбөрийг боловсруулахад ЭМЯ-д мэргэжил арга зүйн үндэслэлийг гарган өгч, мөн тэдгээр бодлого, хөтөлбөрийг хэрэгжилтийг голлон хариуцдаг.

Хорт хавдрын гуравдугаар шатлалын тусламж, үйлчилгээ, үүнд оношилгоо болон төрөлжсөн мэс заслын, туяа, хими, хөнгөвчлөх эмчилгээг үзүүлэх нь ХСҮТ-ийн үйл ажиллагааны өөр нэгэн үндсэн чиглэл юм. Тухайлбал 2010 онд ХСҮТ 72000 орчим хүнд амбулаторийн, 7176 хүнд стационарийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.


Үндэсний төвийн хувьд хорт хавдрын чиглэлээр хийгдэж байгаа судалгаа, мөн хорт хавдрын үндэсний бүртгэл, мэдээллийг хариуцан зангидаж байна. 2007 онд шинэчлэгдэн байгуулагдсан ХСҮТ-ийн эрдмийн зөвлөл нь хавдар судлалын чиглэлээр хийгдэх эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг Монгол Улсын хүн амын дунд зонхилон тохиолдох хавдрын тархвар зүй, хавдрыг хянах бодлоготой уялдуулан тодорхойлсон нь томоохон ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийт 15 хүн, үүнд академич 2, анагаахын шинжлэх ухааны доктор 5, анагаах ухааны доктор 10 ажиллаж байна.

ХСҮТ нь 2000 оноос эхлэн хавдар судлаач эмчийг бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх ажлыг хариуцаж байна. Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, давтан сургалтын зөвлөлийн 2010 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн 4 тоот шийдвэрээр “Хавдар судлаач эмчийн мэргэжлээр үндсэн мэргэжил эзэмшүүлэх резиденсийн 1 жилийн сургалт”-ыг 4 хүртэл жилийн хугацаатайгаар эрхлэх эрхээ шинэчилсэн. Мөн тус зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын шийдвэрээр хавдрын чиглэлээр төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, сургалтын эрхийг шинээр аваад байна.

Бүтэц, хүний нөөц

2010 оны байдлаар ХСҮТ нь бүтцийн хувьд 9 алба, 10 тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Хэвтэн эмчлүүлэх хэсэг нь 190 ортой, үүний зэрэгцээ хөнгөвчлөх эмчилгээний 16 орны хүчин чадалтай.

Дүрслэл 1: Хавдар Судлалын Үндэсний Төвийн бүтэц



Хүний нөөцийн хувьд нийт 365 ажиллагсадтай, үүнд их эмч 85, эм зүйч 5, сувилагч 112, мөн инженер, техникч, лаборант, эм найруулагч, үйлчлэгч, санхүүгийн ажилтан зэрэг нийт 160 ажилтан хамрагддаг. Эмч, эмнэлгийн мэргэжилтний 16.6 хувь нь магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, 34 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, эмнэлгийн дунд мэргэжилтний 40% нь бакалавр зэрэгтэй, бусад нь дипломын боловсролтой. Эмнэлгийн мэргэжилтний 71,8 хувь нь 30-50 насны хөдөлмөрийн насны хүмүүс юм. Бүх эмч болон нийт сувилагчдын 70 хувь, бусад дунд мэргэжилтний 47 хувь нь төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн.

Дэд бүтэц болон барилга байгууламж

ХСҮТ нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт, эзэмших эрхийн гэрчилгээ бүхий нийт 38008 м² газарт байрладаг. 1982 онд ашиглалтад орсон, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандартын дагуу, тоосго ба бетон материалаар баригдсан 4 давхар барилга нь нийт 20000 м² талбайтай, 2кг/см²-ийн даацтай, галд тэсвэрлэх чанар сайтай, гэрэл цахилгаан, дулаан, радио-холбоо дотуур холбооны 100 цэгтэй, интернет холболттой, халуун, хүйтэн болон цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбогдсон юм. Тус төв нь оношилгоо, эмчилгээний өвөрмөц тоног төхөөрөмж бүхий улсын онцгой объект хэмээн тооцогддог.

Гадаад харилцаа

1995 оноос эхлэн Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-тай хамтран төслүүдийг хэрэгжүүлсээр ирсэн нь туяа эмчилгээг хөгжүүлэхэд голлох үүргийг гүйцэтгэсээр иржээ. 2009 онд Монгол Улс ОУАЭА-ийн ПАКТ¹ хөтөлбөрийн жишиг наймдахь орноор сонгогдсон нь хорт хавдрын оношилгоо, эмчилгээний цаашдын хөгжилд багагүй хувь нэмрийг оруулах болно. Мөн Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу 2009-2013 оны хугацаанд АНУ-ын Мянганы сорилтын сан (МСС)-гийн санхүүжилтээр халдварт бус өвчин, үүний дотор зарим хорт хавдраас² сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ ХСҮТ нь гадаадын ижил үйл ажиллагаа эрхэлдэг төв, эмнэлэг, байгууллагатай хоёр талын харилцааг хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна. Тодруулбал дараах байгууллагатай санамж бичигт гарын үсэг зурж, хамтран ажиллаж байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Өмнөд Солонгос Улс (БНӨСУ)-ын Коняны Их сургуулийн эмнэлэг (2011 оноос),
- Тайваны үндэсний их сургуулийн эмнэлэг,
- БНӨСУ-ын Радиологи, анагаахын шинжлэх ухааны хүрээлэн,
- БНӨСУ-ын Их сургуулийн Анагаахын төв,
- Япон Улсын Улаан загалмайн нийгэмлэгийн эрүүл мэндийн төв.

¹ Programme of Action for Cancer Therapy

² Умайн хүзүү, хөхний хорт хавдар

Хорт хавдрыг хянах тогтолцооны өнөөгийн байдал

Хорт хавдрын өвчлөлийн өнөөгийн байдал, цаашдын төлөв

Монгол Улсад сүүлийн 10 жилийн байдлаар хорт хавдрын шинээр бүртгэгдэж буй тохиолдлын тоо тогтмол өссөөр, 2010 оны байдлаар 4466 шинэ тохиолдол бүртгэгдэж, тэдгээрийн 60 орчим хувь нь тухайн жилдээ нас баржээ. Хорт хавдраас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын шалтгааны дунд 2 дугаарт бичигдэж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсад нас барж буй 5 хүний нэг нь хорт хавдрын улмаас нас барж байна.³

Сүүлийн 10 жилийн байдлаар нийт хавдрын шинэ тохиолдлын дотор дараах таван байрлалын хорт хавдар зонхилж байна. Үүнд: элэг (37.4%), ходоод (14.8%), уушги (9.2%), улаан хоолой (8.2%), умайн хүзүү (7.5%) тус тус эзэлж байна. Хүйсийн хувьд авч үзвэл, эрэгтэйчүүдийн дунд уруул, ам, залгиурын хорт хавдар 5 дугаарт, харин эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний хорт хавдар 2 дугаарт ордог. Үүний зэрэгцээ эмэгтэй хүйсэнд хөхний өмөнгийн тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна. **Error! Bookmark not defined.**

Хорт хавдрын шинэ тохиолдол, нас баралтын зэрэгцээгээр нийт хүн амын дундах хорт хавдрын өвчлөлийн тархалт нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2000 оны байдлаар 100000 хүн амд хорт хавдрын тархалт 283.6, шинэ тохиолдол 119.4, нас баралт 92.3 байсан бол 2009 онд 437.9; 153.0; 116.7 болж тус тус нэмэгджээ. **Error! Bookmark not defined.**

Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл

Хорт хавдрын өвчлөлд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйл, зан үйлийн нөлөөлөл хүн амын дунд түгээмэл байна. 2009 онд хийсэн “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох судалгаа”-гаар монгол 5 хүн тутмын 1 (26,4%)-д, 45-с дээш насны 2 хүн тутмын 1 (53,8%)-д халдварт бус өвчин (ХБӨ)-ний 3-аас дээш эрсдэл хавсран тохиолдож байна. Тодруулбал, нийт хүн амын 39,8% илүүдэл жинтэй ба үүнээс 12,5% нь таргалалттай байна. Монгол хүн хоногт 1.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын зөвлөмж хэмжээнээс 3.2 нэгжээр доогуур байна.

Мөн уг судалгаагаар эрэгтэйчүүдийн 39.7%, эмэгтэйчүүдийн 15,1% нь архийг хэтрүүлэн хэрэглэдэг дадалтай ажээ. Түүнчлэн хүн амын 27,7%, үүнээс эрэгтэйчүүдийн 48,0%, эмэгтэйчүүдийн 6,9% тамхи татдаг нь тогтоогджээ. Судалгаанд хамрагдсан 2 хүн тутмын 1 нь (42,9%) гэрийн орчинд, 3 хүн тутмын 1 нь (35,6%) ажлын байрандаа дам тамхидалтанд өртөж байна.

Мөн 2009 оны эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад нийт халдварт өвчний 17.2%-ийг вирүст гепатит эзэлж байна. Нийт вирүст гепатитийн дотор гепатит (В) - 10.9%, гепатит (С) - 1.9%-ийг тус тус эзэлж байна.

³ Хавдар судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн алба, 2010 он


Хорт хавдрыг хянах бодлого

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2007-2013”-ийн хүрээнд хорт хавдраас сэргийлэх, тэмцэх ажил бодлогын түвшинд зохицуулагдаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр 2008-2013” (цаашид дэд хөтөлбөр гэх)-ийг боловсруулан 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь хорт хавдраас сэргийлэх, хянах ажилд илүү анхаарал тавьж, хэрэгжүүлэхэд томоохон хувь нэмрийг оруулж байна. Мөн 2010 онд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах хороог эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан байгуулсан нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мөн оролцогч талуудын уялдааг сайжруулах, улмаар үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнтэй болгоход зохих хувь нэмэр оруулж байна.

Хорт хавдрын тусламж, үйлчилгээний тогтолцоо

Хорт хавдраас сэргийлэх, хянах, хорт хавдартай өвчтөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх ажлыг голлон гурван шатлал бүхий эрүүл мэндийн тогтолцоогоор дамжуулан хүргэж байна.

Дүрслэл 2: Монгол улсын хорт хавдрын тусламж, үйлчилгээний тогтолцоо



Анхан шатны тусламж, үйлчилгээний түвшинд дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн, хавдрын эрсдэлт зан үйлийг өөрчлөх, хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, эмчлэх, хавдартай өвчтнийг хянах, бүртгэх, зарим хавдрыг эрт илрүүлэх ажил хийгдэж байна.

Хоёр дахь шатлал буюу аймгийн нэгдсэн эмнэлэг (АНЭ), дүүргийн эрүүл мэндийн нэгдэл (ДЭМН)-ийн түвшинд анхан шатнаас шилжүүлсэн, хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийн оношийг тодруулах нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хорт хавдартай өвчтөнд хими эмчилгээ хийх, даамжирсан хорт хавдартай өвчтөнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Түүнчлэн умайн хүзүүний хавдрын урьдал өвчнийг эсзүйн шинжилгээгээр оношилж, эмчилж байна. Мөн дараагийн шатлалын тусламж, үйлчилгээ шаардлагатай хорт хавдартай өвчтнийг шилжүүлэх асуудлыг хариуцаж байна.

Гурав дахь шатлал буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, клиникийн нэгдсэн эмнэлэг, төвийн түвшинд аймаг, дүүргээс шилжүүлсэн хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийн оношийг эцэслэн батлах, мөн хорт хавдартай өвчтөнд өмнөх шатлалд хийгдэх боломжгүй хорт хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээг хийх асуудлыг шийдвэрлэж тухайн шатлалд тусламж, үйлчилгээг авсан өвчтнийг нэг, хоёрдахь шатлалын хяналт, хөнгөвчлөх эмчилгээнд шилжүүлж, хавдрын нарийн мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна.

Бүдүүн, шулуун гэдэсний ба бөөр, шээс ялгаруулах замын хавдрын зарим хагалгаа Улсын клиникийн төв эмнэлгийн бүдүүн-шулуун гэдэсний болон бөөрний мэс заслын мэс заслын тасагт, мэдрэлийн гаралтай хавдрын мэс заслын эмчилгээ Шестины нэрэмжит клиникийн нэгдсэн 3-р эмнэлгийн мэдрэлийн мэс заслын тасагт, хүүхдийн цусны хавдрын оношилгоо, эмчилгээ болон зарим хавдрын мэс заслын эмчилгээ Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хүүхдийн цусны ба мэс заслын тасгуудад (ерөнхий, нүд, бөөр) тус тус хийгдэж байна. Үүнээс бусад бүх байрлалын хавдрын мэс заслын эмчилгээ Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-д хийгддэг.

ХСҮТ нь хорт хавдраас сэргийлэх, хянах болон хорт хавдрын тусламж, үйлчилгээний бодлогыг мэргэжлийн түвшинд боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцаж байна. Үүний зэрэгцээ хорт хавдрын оношилгоо болон мэс засал, хими, туяа, хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр гуравдахь шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, хорт хавдрын оношилгоог хэт авиа, рентген, уян дуран, компьютер томограф зэрэг дүрс оношилгооны аргуудыг ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ эс,эдзүйн шинжилгээгээр хавдрын гарал үүслийг тодорхойлж, хавдрын маркер тодорхойлох, иммуногистохими, экспресс эдзүйн шинжилгээ зэрэг аргуудыг нэвтрүүлж эхлээд байна.

ХСҮТ-ийнхэвтэн эмчлүүлэх 190 орны 21 нь өдрийн эмчилгээний зориулалттай. Стационари нь мэс заслын клиник, мэс заслын бус клиник гэсэн

үндсэн 2 хэсэгт хуваагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Мэс заслын клиник нь ерөнхий мэс засал, эрчимт эмчилгээ, элэг цөс, нойр булчирхайн мэс засал, эмэгтэйчүүдийн мэс заслын тасгуудтай. Тус клиник жилдээ 2500 орчим өвчтөнд хавдрын мэс заслын тусламжийг үзүүлдэг ба сүүлийн жилүүдэд эрхтэн хадгалах, судас залгах бичил болон дурангийн мэс засал, радио хяналтат мэс ажилбаруудыг шинээр нэвтрүүлэн, үр дүнтэй хийж байна.

Мэс заслын бус клиник нь туяа, хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасгуудтай. Туяа эмчилгээний тасаг нь энэ төрлийн эмчилгээг хийдэг, улсын хэмжээний ганц нэгж бөгөөд кобальт-60 үүсгүүртэй зайн болон дотуур туяа эмчилгээний аппаратаар туяа эмчилгээг хийдэг. Хими эмчилгээнд одоогоор 10 орчим төрлийн хими эмчилгээний эм бэлдмэлийг дангаар болон хослуулсан аргаар хийж байгаа ба паклитаксол, оксалиплатин, этапозид, эпирубицин зэрэг химийн шинэ эмийг жил бүр, бага багаар эмнэлзүйд нэвтрүүлж байна. Хөнгөвчлөх эмчилгээний 16 ортой тасаг нь хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээ хийх боломжгүй, амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн болон түүний гэр бүлийнхэнд өвдөлт намдаах, өвчтний зовиур шаналгааг багасгах эмийн эмчилгээний зэрэгцээ нийгэм, сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хөнгөвчлөх эмчилгээний их эмч, сувилагчаас гадна хоол зүйч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч оролцсон багийн үйл ажиллагаагаар үзүүлж буйгаараа онцлог юм.

III. ХАВДАР СУДЛАЛЫН САЛБАРЫН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Байгууллагын дотоод орчны шинжилгээ	
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
Давуу тал	Сул тал
- Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2006-2013), Хорт хавдраас сэргийлэх хянах, дэд хөтөлбөр (2008-2013)-ийн хүрээнд ойрын бодлого тодорхойлогдсон. - Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2011-2021)-ний хүрээнд хөгжлийн урт хугацааны бодлого тодорхойлогдсон. - Байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэл тодорхой. - Эрүүл мэндийн сайдын 2010 оны 140 тоот тушаалаар баталсан бүтцийн хүрээнд бүрэн орон тоогоор ажилладаг. - Захирлын зөвлөл 7 гишүүнтэйгээр, захиргааны зөвлөл 31 гишүүнтэйгээр тогтмол үйл ажиллагааг явуулж, аливаа асуудлыг хамтын зарчмаар шийдвэрлэдэг.	- Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт хангалтгүй. - Хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өрсөлдөгч байгууллага байхгүй. - Батлагдсан орон тоо нь үзүүлж буй тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй харьцуулахад хүрэлцдэггүй (жишээ нь эмч сувилагчийн харьцаа олон улсын жишигт хүрдэггүй г.м.). - Эмнэлгийн зохион байгуулалт, удирдлагын чиглэлээр суралцсан мэргэжилтэн хомс. - Хавдрын үндэсний бүртгэл нь эмнэлэгт суурилсан тогтолцоотой. - Цахим сүлжээний зарим тоног төхөөрөмж, тусгай зориулалтын програм хангамж дутагдалтай. - Судалгаа шинжилгээний ажилд зориулсан төсөв, хариуцсан орон тооны ажилтан, суурь

• Эрдмийн зөвлөл нь 15 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлдог. • Жил бүрийн төлөвлөгөөг хамт олны оролцоотойгоор боловсруулдаг. • Төлөвлөлт, хяналт –шинжилгээ, үнэлгээний байнгын ажиллагаа бүхий багтай. • Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, жилийн тайланг хамт олондоо тогтмол танилцуулж, хэлэлцүүлдэг. • Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг жил бүр зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслээр нэгдсэн журмаар хангадаг. • Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэс заслын болон мэс заслын бус клиник, зөвлөх поликлиник зэрэг төрөлжсөн үйлчилгээний бүтцийн дагуу үзүүлдэг. • Эмийн эмчилгээг зохицуулах хороо, Халдвар хяналтын хороо, Цус цусан бүтээгдэхүүнийг зохицуулах зөвлөл, Цацрагийн аюулгүйн алба, Ёс зүйн хороо тус тус ажилладаг. • Нийт тасаг, алба цахим сүлжээнд холбогдсон. • Байгууллагын цахим хуудас байнгын ажиллагаатай. • Хорт хавдартай өвчтөнд үзүүлэх 3 дугаар шатлалын тусламж, үйлчилгээ манай байгууллагад төвлөрдөгтэй холбоотой үйлчлүүлэгчид ээлтэй, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийг зорилгоо болгон ажилладаг.. • Шинэ технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхийн хамт түүн дээр ажиллах эмч, сувилагч, инженер техникийн ажилтныг багаар нь сургах цогц бодлогыг баримталдаг.	судалгаа хийх лаборатори байхгүй. • Гамшиг тохиолдсон үед хэрэглэх нөөц хангалтгүй, ажиллах баг туршлагагүй.
--	---

САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	
Давуу тал	Сул тал
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, баримталдаг. - Санхүү, нягтлан бодох бүртгэлийн нийт ажилтнууд тухайн мэргэжлээрээ дээд боловсрол эзэмшсэн. - Өр, авлагагүй ажилладаг. - Аудит, татвар, нийгмийн даатгалын болон бусад холбогдох байгууллагын төлөвлөгөөт санхүүгийн шалгалт тогтмол хийгдэж, эдгээр шалгалтаар зөрчилгүй үнэлэгддэг.	- Төсвийн бүрдүүлэлтэд эрүүл мэндийн даатгалаас авдаг санхүүжилтийн хувь бага. - Үндсэн үйл ажиллагааны орлого нь санхүүжилтийн нэг эх үүсвэр болдог. Гэвч үндсэн үйл ажиллагааны орлогын 70 хувь нь зардлын хуваарилалтад нь тусгагддагаас төсөв дутагддаг. Энэ байдал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг. - Санхүү, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг сайжруулах шаардлагатай. - Жилийн төсөв бодит хэрэгцээнд хүрэлцдэггүй.
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ	
Давуу тал	Сул тал
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зориулсан байртай. Барилгын өргөтгөл баригдаж байгаа. - Жил бүр тодорхой төлөвлөгөөний дагуу засвар, тохижилтын ажил хийгддэг. - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тодорхой төлөвлөгөөний дагуу хийдэг. - Эмнэлгийн ор 100 хувь шинэчлэгдсэн, цагаан хэрэгсэл, хагалгаанд орсон өвчтөн, түүний сахиурт зориулсан өмсгөлийг жил бүр шинэчилдэг. - Ажиллагсад хувцаслалтын болон харьцаа, хандлагын батлагдсан журмыг мөрддөг. - Эмч, ажиллагсдад жил бүр шинэ дүрэмт хувцас олгодог. - Төвийн автомашины парк шинэчлэл 100 хувь хийгдсэн. - Дэмжих үйлчилгээг хоол зүйч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг багтаасан багаар үзүүлдэг. - Хэвтэн эмчлүүлэгсдийг оношийг нь үндэслэн эмчилгээний хоолоор хангадаг. - Сар бүр үйлчлүүлэгчдэд зориулсан “Нээлттэй хаалга”-ны өдрийг зохион байгуулдаг. - Хоёрдугаар шатлалын эмнэлэгт алсын зайн оношлогоо, сургалтаар үйлчилгээ үзүүлдэг.	- Одоогийн барилга 30 гаруй жилийн өмнө баригдсан тул өнөөгийн хэрэгцээ, стандартын шаардлагад бүрэн нийцэхгүй. - Засвар, тохижилтын ажилд санхүүжилт хүрэлцдэггүй. - Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зориулсан төсөв хүрэлцдэггүй. - Монгол улсын хэмжээнд технологийн өндөр түвшний зарим оношлогоо /генийн ба хромосомын, ПЭТ г.м./, эмчилгээний аргууд /эрхтэн шилжүүлэн суулгах, тархины хавдрын мэс засал, туяа эмчилгээний зарим технологи/ нэвтрээгүй. - Тендерт шалгарсан зарим эм ханган нийлүүлэх байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжид тасалдал үүсгэдгээс тусламж, үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлдэг. - Гаднах талбайн хүртээмж багатайгаас үйлчлүүлэгчдийн автомашины зогсоол хүрэлцдэггүй. - Нөөцийн авто замыг хааж барилга баригдсанаас осол, гамшгийн үед гарц дутагдах магадлалтай. - Галын болон гамшгийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах арга хэмжээнд төсөв хөрөнгө бага. - Хүн амын эрүүл мэндийн боловсрол харилцан адилгүй байдаг нь тусламж, үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БАЙДАЛ	
Давуу тал	Сул тал
- Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодлогыг боловсруулсан. Бодлогод нийгмийн халамжийн асуудал тусгагдсан. - Ажлын байр бүр ажил үүргийн тодорхойлолттой. - Эмч, мэргэжилтэн 100 хувь мэргэжил олгох сургалтанд хамрагдсан. - Эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100% эмчлэх, эм барих, сувилах мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй. - Багц цагийн биелэлт 90-100% байдаг. - Эмч, эмнэлгийн мэргэжилтний 16,6 хувь нь магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. - Эмч, мэргэжилтний 60 хувь нь урт, богино хугацаагаар гадаадад мэргэжил дээшлүүлсэн. - Эмнэлгийн мэргэжилтний 71,8 хувь нь 30-50 насны хөдөлмөрийн насны хүмүүс. - Албан тушаалын зэрэглэлийн дагуу цалинждаг. - Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд интернет сүлжээгээр мэргэжлийн мэдээлэл авах боломж бүрдсэн. - Нийт эмч, мэргэжилтнүүд компьютерийн энгийн хэрэглээний програм дээр ажиллах чадавхитай. - Эмч, эм зүйч нар нь англи хэлний анхан болон дунд шатны сургалтад 100 хувь, сувилагч, бусад мэргэжилтний 40 гаруй хувь нь анхан шатны сургалтад хамрагдсан. - Сувилагч, бусад дунд мэргэжилтнийг тасралтгүй сургалтанд байнга хамруулдаг. - Байгууллага өөрөө хавдрын чиглэлээр үндсэн мэргэжил олгох, төрөлжсөн мэргэжил мэргэшүүлэх сургалтыг эрхэлдэг.	- Ажлын гүйцэтгэлийг урамшууллын тогтолцоотой холбох төсөв байхгүй. - Өнөөдрийн амьжиргааны өртөгтэй харьцуулахад дунд мэргэжилтний цалин бага байдгаас шаардлагатай ажлын байранд эмнэлгийн дунд мэргэжилтнийг сонгон шалгаруулах боломж байдаггүй. - Албан тушаал ахиж, дэвших боломж бага. - Эмнэлгийн дунд мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах боломж хязгаармагдмал. - Эмч, мэргэжилтний эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадавхи хангалтгүй. - Хоёрдугаар шатлалын хавдар судлаач эмч, хавдрын сувилагч ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажилладаггүй. - Бэлтгэгдсэн хавдар судлаач эмч, хавдрын сувилагч хөдөө орон нутагтаа очиж ажилладаггүй. - Нэг ба хоёрдугаар шатлалд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх талаархи мэдлэг, хандлага хангалтгүй. - Зарим нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн (гистологич, ангиографийн техникч, г.м) дутагдалтай. - Батлагдсан боловч төсөв дутагдалтайгаас аймаг, дүүрэгт хавдрын бүртгэлийн ажилтан бүтэн орон тоогоор ажиллахгүй байна. - Хавдрын зарим нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг Монгол Улсад сургах сургалтын тогтолцоо, хөтөлбөр байхгүй.

Гадаад орчны үнэлгээ	
ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	
Боломж	Бэрхшээл
- Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 12-р сарын 14-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийг батлан, хэрэгжүүлж байна. - Хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд сайжруулах талаар Эрүүл мэндийн сайдын 292 тоот тушаал батлагдсан. - ОУАЭА-ийн хөтөлбөр хэрэгжих жишиг 8 дахь орноор сонгогдсон.	- Хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт хангалтгүй. “Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй. - Нийслэл, орон нутагт Эрүүл мэндийн сайдын 292 тоот тушаалын хэрэгжилт хангалтгүй байна. - Улсын хэмжээний хавдрын бүртгэл, мэдээллийн олон улсын түвшний програм хангамж байхгүй. - Хавдрын бүртгэл, мэдээллийн чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүд, эмгэг судлалын төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагуудаас хавдрын өвчлөл, нас баралтын тоон мэдээлэл авах, харилцан мэдээлэх тогтолцоо хангалтгүй. - Хоёр ба гуравдугаар шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй. - Шатлал хооронд өвчтөн шилжүүлэх өнөөгийн тогтолцоо хангалтгүй, тогтвортой бус ажилладаг.

ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД, ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГА	
Боломж	Бэрхшээл
- ОУАЭА-ын хөтөлбөр хэрэгжих жишиг 8 дахь орноор сонгогдсоноор хавдрын тусламж, үйлчилгээг, ялангуяа туяа эмчилгээг хөгжүүлэх таатай боломж бүрдсэн. - ДЭМБ, Монголын мянганы сорилтын сантай хамтран ажилладаг. - Эмч, мэргэжилтнийг гадаадын түнш хавдар судлалын төв, эмнэлэгт сургадаг. - Гадаадын түнш хавдар судлалын төв, эмнэлгийн өндөр мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн ХСҮТ дээр ажлын байран дахь сургалт явуулдаг. - Гадаадын түнш байгууллагаас тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл хандивладаг. - Хорт хавдартай тэмцэх үйл ажиллагаанд дотоодын төрийн бус байгууллагаас дэмжлэг үзүүлэх, хувийн хэвшлээс хандив өргөх нь нэмэгдэж байна.	- Эмч, мэргэжилтнийг гадаадад сургахад шаардлагатай санхүүжилт байдаггүй. - Хандиваар авсан зарим хэрэглэгдэж байсан тоног төхөөрөмж чанарын шаардлага хангадаггүй, засвар үйлчилгээнд нь бэрхшээл гардаг. - Зарим гадаад, дотоодын төрийн бус байгууллагатай хамтарсан үйл ажиллагаа тогтвортой бус.

IV. ХАВДАР СУДЛАЛЫН САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт:

- Хүн амын эрүүл мэндийн талаархи, үүний дотор хорт хавдраас сэргийлэх талаар мэдлэг, дадал, хандлага сул.
 - Хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх зан үйлийг өөрчлөх харилцаа (ЗҮӨХ)-ны бодлого байхгүй.
 - ХСҮТ, дүүргийн ЭМН, аймгийн Эрүүл мэндийн газарт хавдраас сэргийлэх ЗҮӨХ-ны баг байхгүй.
 - Өрх, сумын эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнуудын ЗҮӨХ-ны ур чадвар сул.
 - Олон нийтэд зориулсан ЗҮӨХ-г явуулахад шаардагдах төсөв хангалтгүй.
- Хавдрын үндэсний бүртгэл, мэдээллийг хүн амд суурилсан тогтолцоотой болгох.
 - Хавдрын үндэсний бүртгэлийн хүн хүчний хүрэлцээ, чадавхи хангалтгүй.
 - Хавдрын үндэсний бүртгэл, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгаа шинжилгээ хийх чадавхи сул.
 - Хавдрын үндэсний бүртгэлийн техник, технологи хоцрогдсон.
 - Хавдрын эрт илрүүлэлтийн мэдээллийн тогтолцоо бүрдээгүй.
 - Хавдрын тохиолдлыг идэвхитэйгээр хайж, бүртгэх механизм бэхжээгүй.
 - Хавдрын олон улсын ангилал (ICD-O болон TNM)-ыг мөрдөж хэвшээгүй.
- Дархлаажуулалтаар сэргийлэх боломжтой хавдрын урьдчилан сэргийлэлт хангалтгүй.

- о Хүний папилома вирусийн дархлаажуулалт хийгддэггүй.
- Хорт хавдрын судалгаа, шинжилгээ хийх чадавхи сул, санхүүжилт хангалтгүй.

Хорт хавдрын эрт илрүүлэлт:

- Хавдрын урьдал болон хорт хавдрыг эрт үеийн шинж тэмдгээр нь болон зохих түвшний сорил, шинжилгээгээр цаг алдалгүй илрүүлэх чадавхи сул.
 - о Эрүүл мэндийн 1, 2 дугаар шатлалын эмч, эмнэлгийн мэргэжилтний хорт хавдрыг эрт илрүүлэх, мэдлэг, чадвар, хандлага сул.
- Хорт хавдрыг эрт илрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалжийн хангамж хангалтгүй. Хавдрын эрт илрүүлэлтийн эргэн дуудах тогтолцоо бүрдээгүй.
- Хавдрын урьдал болон хорт хавдрын эрт үеийн шинж тэмдгийн талаархи хүн амын мэдлэг хангалтгүй, илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад нэн даруй хандах хандлага төлөвшөөгүй.
 - о Хорт хавдрын эрт илрүүлэлтийн талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл хангалтгүй.
 - о Эрүүл мэндийн асуудал гарахад эрүүл мэндийн байгууллагад эрт хандах хүн амын хандлага сул.

Хорт хавдрын оношлогоо, эмчилгээ:

- Хоёрдугаар шатлалд үзүүлж буй хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй.
 - о Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн бүтцэд хавдрын тасаг байгуулагдах шийдвэр хэрэгжээгүй.
 - о Хоёрдугаар шатлалд хими эмчилгээг хийх нөхцөл, боломж хангалтгүй.
 - о Хавдрын эс, эдзүйн шинжилгээний чадамж сул.
- ХСҮТ-ийн оношлогоо, эмчилгээний зарим чиглэл олон улсын жишигт хүрээгүй.
 - о Орчин үеийн оношлогоо, эмчилгээний зарим тоног төхөөрөмж хангалтгүй.
 - о Эрхтэн шилжүүлэн суулгах боломж бүрдээгүй.
 - о Дурангийн болон бичил мэс заслын зарим арга барил нэвтрээгүй.
 - о Эрхтэн хадгалах, нөхөн сэргээх мэс заслын хөгжил сул.
 - о Туяа эмчилгээнд гурван хэмжээст технологи бүрэн нэвтрээгүй.
 - о Хими эмчилгээнд хэрэглэгдэж буй эмийн төрөл цөөн, хангамж хүртээмж хангалтгүй.
 - о Хавдрын эс, эдзүйн лавлагаат тусламжийн хүрэлцээ, чадавхи сул.
 - о Лабораторийн оношлогоонд зарим арга, технологи нэвтрээгүй.
 - о Оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ хангалтгүй.
 - о Зайн оношлогоо, зөвлөгөөт тусламж хангалтгүй, цахим эмнэлгийн хөгжил хангалтгүй.
 - о Барилга байгууламж, дэд бүтцийн багтаамж оношлогоо, эмчилгээний хэрэгцээг хангахгүй байна.

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ:

- Даамжирсан хорт хавдартай өвчтөнд гэрээр үзүүлэх сувилгаа, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний цогц чадамж сул.
 - о Нэг ба хоёрдугаар шатлалын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний эмч мэргэжилтний хүрэлцээ хангалтгүй, чадавхи сул,
 - о Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн бүтцэд хөнгөвчлөх эмчилгээний эмч бүхий хавдрын тасаг байгуулагдах шийдвэр хэрэгжээгүй.
 - о Хөнгөвчлөх эмчилгээний зардал орон нутгийн төсөвт тусгагдаагүй.

- о ХСҮТ-ийн хөнгөвчлөх эмчилгээний тасаг нь ачаалал ихтэйгээс арга зүйн төв гэхээс илүү хэвтэн эмчлүүлэх үйл ажиллагааг голлосон.

Удирдлага, зохион байгуулалт:

- Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн орон нутагт хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт төлөвшөөгүй.
- Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн санхүүжилт хангалтгүй.
- Хорт хавдрын тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалаас ногдож буй санхүүжилт бага.
- Орон нутгийн эрүүл мэндийн удирдлагын зүгээс хорт хавдрын тусламж, үйлчилгээний талаарх ойлголт, хандах хандлага хангалтгүй.
- Өвчтнийг шатлал хооронд шилжүүлэх өнөөгийн тогтолцоо боловсронгуй бус.

V. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Сүүлийн 5 жилийн дундаж	Суурь он: 2010	2011	2012	2013	2014	2015
Нэг. Үндэсний хэмжээний хорт хавдрын шалгуур үзүүлэлт (100.000 хүн амд)								
1	Хавдрын шинэ өвчлөл	150.0	160.6	160.0	155.0	150.0	145.0	140.0
2	Хавдрын нас баралт	113.2	105.5	105.0	100.0	95.0	90.0	90.0
3	Хорт хавдрын эрт илрүүлэлтийн хувь	22.1	21.9	22.1	23.1	24.1	25.1	26.0
4	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн хувь	48.1	42.4	43.0	45.0	48.0	50.0	50.0
5	Умайн хүзүүний хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь	31.8	30.4	31.8	33.2	34.4	35.6	36.8
6	Хөхний хорт хавдрын эрт илрүүлэлтийн хувь	36.7	38.0	39.0	40.0	41.0	42.3	43.0
7	Хөхний хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь	33.6	31.5	33.6	35.7	37.8	39.9	40.0
Хоёр. Эмнэлгийн тусламж үйлчилгээний шалгуур								
1	Амбулаторийн нийт үзлэгт хөдөөний харьяалалтай хүний эзлэх хувь	33.6	36.1	33.6	31.1	28.6	28.0	27.0
2	Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	22.3	21.2	22.3	23.4	24.5	25.6	26.0
3	Амбулаторид шинээр оношлогдсон хорт хавдрын эрт үеийн (I, II) эзлэх хувь	36.2	34.3	36.1	36.5	37.0	37.5	38.0
4	ХСҮТ-д шинээр оношлогдсон хорт хавдрын эс, эдзүйн шинжилгээгээр баталгаажсан хувь	71.5	78.6	79.6	80.0	80.5	81.0	81.5
5	Туяа эмчилгээ хийгдсэн үйлчлүүлэгчдээс амбулаториор хийгдсэн туяа эмчилгээний эзлэх хувь	58.2	62.1	65.3	65.0	65.5	67.0	67.5
6	Стационарт давтан хэвтэлтийн хувь	72.1	70.3	70.1	69.0	68.0	67.0	66.0
7	Стационарт анх хэвтэгсдийн дунд эрт үеийн (I, II) хавдартай өвчтний эзлэх хувь	21.0	28.0	28.0	29.0	30.0	31.0	32.0
8	Эмнэлгийн нас баралтын хувь	0.6	0.8	0.8	0.7	0.7	0.6	0.6

9	Үндсэн оношийн тохирооны хувь	96.8	100	100	100	100	100	100
10	Мэс заслын хүндрэлийн хувь	0.7	0.6	0.6	0.5	0.5	0.5	0.5
11	Төгс хагалгааны хувь	49.4	49.5	51.2	51.5	52.0	52.5	53.0
Гурав. Хоёрдахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын Хавдрын тусламж, үйлчилгээний шалгуур үзүүлэлт								
1	Нийт үзлэгээс урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	-	43.3	44.0	44.5	45.0	45.5	46.0
2	Шинээр оношлогдсон хорт хавдрын эс, эдзүйн шинжилгээгээр баталгаажсан хувь	-	16.1	16.5	17.0	18.0	19.0	20.0
3	Хорт хавдар шинээр оношлогдсон хувь	-	15.0	15.5	16.0	16.5	17.0	17.5
4	Шинээр оношлогдсон хорт хавдрын эрт үеийн (I, II) эзлэх хувь	-	19.8	20.0	22.5	23.0	23.5	24.0

VI. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

5.1. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЛСЫН ХАРАА:

Ази, Номхон Далайн бүсийн хавдар судлалын тэргүүлэх байгууллага болох.

5.2. ЭРХЭМ ЗОРИЛГО:

Үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байхад оршино.

5.3. ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:

- Үйлчлүүлэгч,
- Хамт олон, хувь хүн,
- Мэргэжлийн тангараг, ёс зүй,
- Байгууллагын түүх, уламжлал, нэр хүнд.

5.4. АЖИЛЛАХ ЗАРЧИМ:

- Чанартай, тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх,
- Үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэх,
- Мэргэжлийн тангараг, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх,
- Хамт олны дунд тэгш эрхтэй, нээлттэй, эвсэг, ажил хэрэгч уур амьсгалыг бүрдүүлэх,
- Удирдах, удирдуулах ёс зарчмыг хүндэтгэх,
- Аливаа ажилд бүтээлч, санаачлагатай хандах,
- Чадавхийг бэхжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх,
- Нотолгоонд суурилсан анагаах ухааны зарчмыг баримтлах,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, үр дүнг практикт нэвтрүүлэх,
- Тусламж, үйлчилгээг байнга сайжруулж, дэвшилтэт техник технологи, арга барилыг цаг үед нийцүүлэн нэвтрүүлэх,
- Хөрөнгө оруулалт, хуваарилалтыг оновчтой хийх, эдийн засгийн үр ашигтай ажиллах

- Гадаад, дотоодын холбогдох байгууллагатай сайн түншийн харилцааг хөгжүүлэх,
- Олон нийтэд хандсан үйл ажиллагааг тогтмол явуулж байх.

5.5. ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН:

Алсын үр дүн:

- Хорт хавдрын шинэ тохиолдлын гуравны нэгээс нь урьдчилан сэргийлэх,
- Хорт хавдрын шинэ тохиолдлын гуравны нэгийг эрт илрүүлсний үндсэн дээр төгс эмчлэх,
- Хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээний аргаар төгс эмчлэгдэх боломжгүй, хожуу үе шатандаа буй хорт хавдартай хүмүүсийн гуравны хоёрыг хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамруулах

Ойрын үр дүн:

- Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд нярай хүүхдийг В гепатитийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна.
- Гепатит В вирусийн халдвар авах өндөр эрсэлтэй нөхцөлд ажилладаг эмнэлгийн ажилтныг дархлаажуулалтад хамруулсан байна.
- Бэлгийн харьцаанд орохоос өмнөх насны охидыг хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна.
- Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлс, үүнд согтууруулах ундаа, тамхи, орчны болон мэргэжлийн хортой нөлөөллийг бууруулах хууль эрхзүйн орчинг сайжруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулсан байна.
- Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.
- Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэхэд чиглэсэн ЗҮӨХ-г үндэсний хэмжээнд явуулах тогтолцоог бэхжүүлсэн байна.
- Хорт хавдраас сэргийлэх талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулсан байна.
- Зарим эрхтний хорт хавдрын эрт үед илрэх шинж тэмдгийн талаархи мэдээллийг хүн ам, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарт хүргэж, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад цаг алдалгүй хандах дадлыг хэвшүүлсэн байна.
- Эрүүл мэндийн салбарын, ялангуяа анхан шатны тусламж үйлчилгээний хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, эмчлэх цогц чадамжийг дээшлүүлсэн байна.
- Аймаг, дүүргийн эмнэлгийн хорт хавдрыг оношлох чадавхийг сайжруулсан байна.
- Аймаг, дүүргийн эмнэлгийн бүтцэд хавдрын тасгийг байгуулж, үйл ажиллагааг нь бэхжүүлсэн байна.
- Гуравдугаар шатлалын холбогдох төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлгийн хорт хавдрыг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулсан байна.
- ХСҮТ-ийн хорт хавдрыг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулсан байна.
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, бэхжүүлсэн байна.

VII. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ МАТРИЦ

Байгууллагын эрхэм зорилго: Үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байхад оршино.

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ	ХҮРЭХ ҮР ДҮН	БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН АЖИЛЛАГАА	ҮЙЛ	ХУГАЦАА (2007- 2016 ОН)						Хариуцах тасаг, нэгж/ байгууллага
				2011	2012	2013	2014	2015	2016	
1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ										
ХЭТИЙН ЗОРИЛТ: /Хорт хавдрын төрөлжсөн тусламж, үйлчилгээг бэхжүүлэх/										
1.1 Байгууллагын стратеги төлөвлөгөөнд Үндэсний хөтөлбөрийн арга хэмжээг тусган хэрэгжүүлэх	ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт сайжирч, үечилсэн үнэлгээ хийгдсэн байна.	ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх								ЭМЯ, ЭМГ, ХСҮТ ЭШСМА Олон улсын байгууллага /ДЭМБ/, ТББ
		Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх								
		Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд үечилсэн үнэлгээ хийх								
1.2 Зонхилох байрлалын хавдрыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх үр дүнтэй арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	Хорт хавдрын тусламж, үйлчилгээ сайжирна	БОЭТ, аймаг, дүүргийн эмнэлэгт хавдрыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх хүчин чадлыг бэхжүүлэх								ЭМЯ, Аймаг, хотын ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ХСҮТ Олон улсын байгууллага/ ТББ
		I, II шатлалын хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн ажилтан нарыг сургаж, чадавхийг нь дээшлүүлэх								
		Өндөр нарийн мэргэжлийн эмчийг тусгай хөтөлбөрийн дагуу, тодорхой хугацаагаар БОЭТ, аймаг болондүүрэгт ажиллуулах								

		Хүн амын дунд цусаар дамжих халдвар /вируст гепатит С, вируст гепатит В г.м./-ыг эмнэлгийн багаж, хэрэгслээр дамжин тархахаас сэргийлж, улсын хэмжээнд ариутгалын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх							
		В гепатитаас сэргийлэх вакциныг хүн амын дунд хүртээмжтэй, чанартай хийж, В гепатитын өвчлөл, түүнээс үүдэлтэй элэгний хатуурал, элэгний анхдагч өмөнг бууруулах							
1.3 Хавдрын үр дүнтэй шилжүүлгийн тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлэх	Хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирсан байна	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрт тохирсон хорт хавдрын шилжүүлэх тусламжийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж хэрэгжүүлнэ.							ХСҮТ ба тасаг, нэгжүүд;
		Аймаг, дүүргийн эмнэлгийн бүтцэд хавдрын тасгийг байгуулж, үйл ажиллагааг нь бэхжүүлнэ.							
		Хавдрын үндэсний бүртгэлийн нэгдсэн програм хангамжийг орон даяар нэврүүлэн, үйл ажиллагааг нь тогтмолжуулах							
		Өвчтнийг хяналтад эргэн дуудах, холбогдох Re-call үйлчилгээг тогтмолжуулах							

1.4 Хорт хавдрын хөнгөвчлөх болон өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хүртээмжийг аймаг, дүүргийн эмнэлэг болон ХСҮТ-д нэмэгдүүлэх							ХСҮТ, Монголын хавдрын Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний нийгэмлэг
		Хими, туяаны өдрийн эмчилгээний орыг нэмэгдүүлэх							ХСҮТ-ийн хими, туяа эмчилгээний тасаг
		Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний сургалтын хөтөлбөр боловсруулан сургалт явуулах							ЭМГ, ХСҮТ - ЭШСМА, Монголын хавдрын Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний нийгэмлэг
		Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний эмнэлзүйн удирдамжийг шинээр гаргаж, практикт хэрэглээг нэвтрүүлэх							
		Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний бүртгэл, мэдээллийн талаар асуудал боловсруулж, холбогдох газраар шийдвэрлүүлэх							ХСҮТ - ЭШСМА,
1.5 Хорт хавдрын оношилгоо, эмчилгээнд Анагаах ухааны орчин үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, чадавхийг	Хавдрын оношилгоо, эмчилгээний чадавхи сайжирсан байна.	Нөхөн сэргээх мэс засал, микро мэс заслын чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх, тоног төхөөрөмжөөр хангах							ЭМЯ, ХСҮТ ба тасаг нэгжүүд, Олон улсын байгууллага
		Ходоод, улаан хоолой, гэдэсний залгаасыг орчин үеийн техник ашиглан хийх							

сайжруулах		Умайн хүзүүний хавдрыг цууны хүчлээр оношлох, хөлдөөх аргаар эмчлэх							
		Хэвлийн болон эмэгтэйчүүдийн хавдрыг дурангаар оношлох, эмчлэх Үүнд: • Дутагдалтай байгаа багаж тоног төхөөрөмжөөр хангах • Сургалтын мэс засал хийхэд шаардлагатай амьтан тэжээх лабораторитой болох Эрүүл мэндийн даатгалд дурангийн мэс заслыг оруулах							
		Элэгний оношлогоо эмчилгээний төвийг байгуулж, “Living donor transplantation of liver” мэс заслыг хийх хууль эрх зүйн орчин, тоног төхөөрөмж, боловсон хүчнийг бэлтгэх							
		Дурангаар хийх хавдрын мэс заслын аргыг өөрийн эмнэлэгт хөгжүүлэх							
2. ЭМ ЗҮЙ, ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Хавдрын зайлшгүй шаардлагатай эм биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, Эмнэлэг болон лабораторийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулах, Барилгын засвар, харилцаа холбоог тогтмолжуулах замаар үйлчлүүлэгчдийн чанартай үйлчилгээ авах таатай орчинг бүрдүүлэх/									
2.1 Хорт хавдрын эмчилгээний эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг	Хорт хавдрын эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног	Хорт хавдрын эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгслийг хангах тендерийн асуудлаар санал							ЭМЯ ХСҮТ ба тасаг

2.2 Цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг дэмжих, хяналтыг сайжруулах	төхөөрөмжийн ашиглалт сайжирсан байна.	боловсруулж, холбогдох газраар шийдүүлэн хэрэгжүүлэх							нэгжүүд, Олон улсын байгууллага
		Зайлшгүй шаардлагатай эм /ЗШЭ/ -ийн бүртгэл дэх Хорт хавдрын эмчилгээнд хэрэглэгдэх эмийн жагсаалтын нэр төрлийг тогтмол шинэчилж, хангах асуудлаар санал оруулах							ТББ; Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд,
		Эмийн зохистой хэрэглээг дэмжих, жор бичилтийг сайжруулах							Төрийн өмчийн хороо
		Эмийн захиалгын олон дамжлагыг багасгах, цахим хэлбэрийн захиалгыг нэвтрүүлэх							
		Хөнгөвчлөх эмчилгээнд ашиглаж буй мансууруулах эмийн эмчилгээний удирдамж боловсруулах							
		Эмч, мэргэжилтнүүдэд цус, цусан бүтээгдэхүүний төрөл, ангиллын талаархи сургалтыг зохион байгуулах							ХСҮТ ба тасаг нэгжүүд ; Цусны төв
		Холбогдох хууль, журмын хэрэгжилтэнд хяналт тавих							

2.3 Үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах, ажиллагсдын ажиллах нөхцлийг сайжруулах	Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нарын чанартай үйлчилгээ авах, үзүүлэх ая тухтай орчин бүрдсэн байна.	Хавдрын тусламж үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагатай холбогдуулан барилгын өргөтгөлийн асуудлыг шийдэх							ЭМЯ, Төрийн өмчийн хороо, ХСҮТ ба тасаг нэгжүүд ; Олон улсын байгууллага ТББ;
		Оношлогооны хэсэг (Амбулатори)-ийг өргөтгөх							Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд
		Эмчилгээний (туяа) хэсгийг өргөтгөх							
		Ажилчдын ажлын байрны нөхцлийг сайжруулах /хувцасны өрөө, шүүгээ, амралтын өрөөтэй болох, дотуур холбоог сайжруулах, өвчтний өрөөнөөс эмч-сувилагч дуудах дохиоллын тоног төхөөрөмжөөр хангах/							
		Хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагааны хангамжийг дээшлүүлэх /нэг удаагийн болон ажлын хувцас, хамгаалалтын шил г.м./							
		Харуул хамгаалалтын хяналтын тоног төхөөрөмжийг сайжруулах							
		Төвийн орох, гарах автозамын урсгалыг өргөтгөх, явган хүний замыг бий болгох,							

		автомашинны зогсоолыг нэмэгдүүлэх							
		Мэс заслын өрөөний агааржуулалт, тоног төхөөрөмжийг сайжруулах							
		Хагалгааны өрөөний тоог нэмэгдүүлэх							
2.4 Шинэ техник, технологи нэвтрүүлэх	Хавдрын оношилгоо, эмчилгээ, үйлчилгээн ий чадавхи сайжирсан байна	Шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах /оношлогоо, эмчилгээний болон хавдрын туяа, хими эмчилгээний тоног төхөөрөмж/							ЭМЯ, Төрийн өмчийн хороо, ХСҮТ ба тасаг, нэгжүүд; Олон улсын байгууллага/ ТББ; Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд
		Хамгаалалтын блок, бэхэлгээ маск бэлтгэх лаборатори байгуулах							
		Химийн тариа найруулах технологийг боловсронгуй болгож, ламинар боксийг ашиглалтанд оруулах							
		Ариутгал, халдваргүйтгэлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах/							
		Лабораторийн чадавхийг дээшлүүлж, иммунологи гистохимийн лабораторийг байгуулах							
		Тоног төхөөрөмжийн урсгал засвар үйлчилгээг сайжруулах							

3. ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ХАРИЛЦАА									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, улмаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох/									
3.1 Хавдрын өвчлөлийг бууруулахад чиглэсэн, үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн МСС-г өргөжүүлэх	Хүн амын Хавдраас урьдчилан сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх мэдээллийн ашиглалт сайжирна	Хүн амд зориулсан хорт хавдрын эрсдэлт зан үйлийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгааны материал боловсруулан хэвлэж, түгээх							ХСҮТ ба тасаг, нэгжүүд;
		Хорт хавдраас сэргийлэхэд чиглэсэн мэдээллийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан тогтмол хүргэх							ЭМГ, ЭМЯ, Олон улсын байгууллага/ТББ
		Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нарт зориулсан ухуулга, сурталчилгааны баримтын хуудас боловсруулан түгээж, мэдээллийг хүргэх							ЭМЯ, ЭМГ, ХСҮТ
3.2 Иргэдэд ХСҮТ-ийн тусламж, үйлчилгээг ойлгуулж таниулах, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах	ХСҮТ-ийн үйлчилгээний талаархи олон нийтийн мэдлэг дээшилж, хандлага сайжирсан байна.	Вэб сайтыг интернетэд байршуулж, тогтмол мэдээллээр баяжуулах							ХСҮТ – ЭШСМА ба бусад тасаг, нэгжүүд;
		Үйлчлүүлэгч төвтэй хүлээн авах, цаг товлох, мэдээллийн лавлах зэрэг үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох							Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд,
		Мэдээллийн төвийг нээж ажиллуулах (утсаар болон цахим хэлбэрээр)							
		Цаг товлох болон захиалгат /эмч сонгох/ үйлчилгээг батлагдсан заавар, журмын дагуу хэрэгжүүлэн тогтмолжуулах							

		ХСҮТ-ийн үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах							
3.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, зөвлөгөө өгөх чадавхийг дээшлүүлэх	Байгууллагын соёл дээшилж, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ нэвтэрсэн байна.	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх чиглэлийн үйл ажиллагааг тогтмолжуулах Мэргэжлийн алдаа, тусламж үйлчилгээний үнэлгээний чиглэлээр мэргэжлийн зөвлөл, мэргэжлийн нийгэмлэгтэй хамтран ажиллах Үйлчлүүлэгчидтэй харилцах харилцааны стандартыг боловсруулж мөрдүүлэх Үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх Эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тохиромжит хувилбарыг сонгож хэрэглэх							ЭМЯ, ЭМГ, ХСҮТ, Хавдрын нийгэмлэг, Эмнэлгийн үйлчилгээний хариуцлагын даатгалын байгууллага
		Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулах, судалгааны дүгнэлт зөвлөмжид суурилсан арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх							

4. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Хавдрын тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах/									
4.1 Хавдрын тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох	Хавдрын тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо бүрэлдэж, үйл ажиллагаа нь жигдэрнэ.	Хавдрын тусламж, үйлчилгээний удирдлагын болон эмнэл зүйн удирдамж, стандартыг шинэчилж, хэрэгжүүлэх							ХСҮТ ба тасаг, нэгжүүд; Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд
		Эмнэл зүйн хяналтын хуудсыг боловсруулж, чанарын хяналтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх							
		Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцох хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулан хэрэгжүүлэх							
		Хяналт үнэлгээний багийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах							
		Өвчтнийг хяналтанд эргэн дуудах Re-call үйлчилгээг тогтмолжуулах							
4.2 Үндэсний хэмжээнд эс, эдзүйн шинжилгээний хяналтын тогтолцоог бий болгох	Хавдрын оношилгооны нотолгоо сайжирсан байна.	Эс, эдзүйн шинжилгээний лавлагаа төв байгуулах							ЭМЯ, ЭМГ, ХСҮТ Лабораторийн тасаг
		Эс, эдзүйн шинжилгээний мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж, эрх авах							
		Хөндлөнгийн хяналтын эксперт бэлтгэх							

5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, Төгсөлтийн өмнөх, дараах болон ажлын байран дахь сургалтыг шинэчлэх/									
5.1 Хавдар судлалын салбарын хүний нөөцийн удирдлагын чадавхи, төлөвлөлтийг сайжруулж, чадавхийг бэхжүүлэх	Хавдар судлалын салбарын хүний нөөцийн удирдлагын чадавхи нэмэгдэнэ.								ХСҮТ, ЭМЯ, ЭМШУИС, Аймаг, дүүргийн НЭ
5.2 Хавдар судлалын мэргэжилтнийг бэлтгэх үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах	Зөв хандлага, өндөр мэдлэг, ур чадвартай эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бэлтгэгдэнэ	Хавдар судлаач эмчийн резиденсийн сургалтыг зохион байгуулж, хавдар судлаач эмч бэлтгэх							ХСҮТ, ЭМЯ, ЭМШУИС, Аймаг, дүүргийн НЭ
		Хавдар судлалын төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжилтнүүдийг бэлтгэх							
		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний I, II шатлалд ажиллагсдын хавдрын чиглэлээр сургалтын тасралтгүй байдлыг хангах							
		ХСҮТ-ийн болон аймаг, дүүргийн хавдар судлаач эмч, сувилагч, лаборант, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар урт, богино хугацааны төлөвлөгөөтэй ажиллах							

		Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн чиглэлийн ном, сэтгүүл, сурах бичиг бусад мэдээллээр хангах							
		ХСҮТ-ийн инженер, техникийн ажилчдад зориулсан ажлын байран дахь сургалтыг тогтмол зохион байгуулах							
		Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өндөр нарийн мэргэжилд мэргэших сургалтанд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх							
5.3 Хавдар судлалын салбарын ажилтнуудын ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэхүйц дэмжлэгт орчин бүрдүүлэх	Эмч, мэргэжилтний ажлын бүтээмж нэмэгдэнэ.	ХСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлэх							
		Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг авах, ахиулах нөхцөл бололцоогоор хангах							
		Аймаг, дүүргийн хавдар судлаач эмч, мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох							
5.4 Хавдар судлалын тусламж, үйлчилгээний шатлал тус бүрд	Хавдар судлалын тусламж, үйлчилгээний чанар	ХСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох							

тохирсон ур чадварын зохистой харьцааг бүрдүүлэх	нэмэгдэнэ.	II шатлал дахь хавдрын тасгийн үйл ажиллагааг дэмжих							
5.5 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сайжирна.	ХСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүйн талаар сургалт зохион байгуулах							
		ХСҮТ-ийн ёс зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах							
6. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Санхүүгийн болон холбогдох нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хавдрын тусламж үйлчилгээний хамралтыг өргөжүүлэх/									
6.1 Мэргэжлийн ур чадвар, мэдлэг, хандлагатай уялдуулан цалин, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох	Санхүүгийн болон нөөц ашиглалтын үр дүн, үр ашиг нэмэгдэнэ.	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, мэдлэг, хандлагатай уялдуулан цалингийн урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох							ЭМЯ, Сангийн яам ХСҮТ
		Төсвөөс гадна бусад санхүүжилтийн эх үүсвэрийг хайж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх							
6.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд Case-mix тогтолцоог нэвтрүүлэх		Санхүүжилтийн арга болон үр дүнг тооцож үнэлэх аргыг уялдуулах талаар санал боловсруулж, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх							ЭМЯ, Сангийн яам, ХСҮТ ба тасаг нэгжүүд,
		Өртөг тооцоход тоног төхөөрөмжийн элэгдэл, хорогдлыг тооцдог болох							

		Тусламж үйлчилгээний өртгийг тооцох аргыг боловсронгуй болгох талаар санал оруулж шийдвэрлүүлэх							
		E-hospital төслийг хэрэгжүүлэх, цахим бүртгэлийг нэвтрүүлэх							
		Зонхилох байрлалын хавдрын Эмнэл зүйн удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх							
6.3 Төсвөөс гадна бусад санхүүжилтийн эх үүсвэрийг хайж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Байгууллагын орлогын эх үүсвэр нэмэгдсэн байна.	Олон улсын түвшинд хүрсэн стандарт удирдамж, технологийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой зарцуулалтын санхүүжилтийг тооцон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх							ЭМЯ, Сангийн яам, ХСҮТ
		Байгууллагын орлогын бусад эх үүсвэрийг судлан үр ашигтай ажиллах /туслах аж ахуй, нэмэлт тусламж, үйлчилгээ г.м./							ЭМЯ, Сангийн яам, ХСҮТ
		Нэмэлт тусламж, үйлчилгээний тохиромжтой, үр ашигтай хэлбэрийг тодорхойлон нэвтрүүлэх							
		Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлогоос олох санхүүжилтийн эх үүсвэрийн хууль, эрх зүйн орчинг судалж, асуудал дэвшүүлэх							ЭМЯ, Сангийн яам ХСҮТ

		Зарим нэр төрлийн тусламж, үйлчилгээг ЭМД-аас санхүүжүүлэх талаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх							ЭМЯ, Сангийн яам ХСҮТ
		Үндэсний хөтөлбөрт тусгагдсан санхүүжилтийг авч, хэрэгжүүлэх талаархи саналыг холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх							ЭМЯ, Сангийн яам ХСҮТ
7. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ									
ХЭТИЙН ЗОРИЛТ /Салбарын хэмжээний хандлагад тулгуурлан Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг нэгтгэн, эрчимжүүлэх, төвлөрлийг сааруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлэх/									
7.1 Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хандлагад тулгуурлан ХСҮТ-ийг хөгжүүлэх	Байгууллагын соёл дээр тулгуурласанүр ашигтай менежментийн тогтолцоо бүрдсэн байна.	Байгууллагын менежментийг сайжруулах ХСҮТ-ийн техник, технологийн шинэчлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах Теле анагаах ухааны үйлчилгээг сайжруулах Хавдрын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх							ХСҮТ ба тасаг, нэгжүүд, Үндэсний хэмжээнд хамтран ажиллах байгууллагууд, Олон улсын байгууллага, ТББ
7.2 Хавдрын хяналт, тандалтын тогтолцоог боловсронгуй болгох	Хүн амд суурилсан Хавдрын үндэсний бүртгэл, мэдээллийн тогтолцоо нэвтэрсэн	ОУ-ын Хавдрын бүртгэл, мэдээллийн нийгэмлэгийн гишүүнд элсэж, нэгдсэн мэдээллийн сүлжээнд хамрагдах							ЭМЯ, ЭМГ ХСҮТ-ийн ЭШСМА ба бусад тасаг,

	байна.	ОУ-ын хавдрын бүртгэлийн кодчиллын тогтолцоог нэвтрүүлэх /ICD-10, ICD-O, summary staging, ICD-9CM/							нэгжүүд
		Мэдээлэл, технологийн хэсгийн нөөц болон чадавхийг нэмэгдүүлэх							
7.3 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх		Эрдмийн зөвлөлийг өргөтгөж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах							ЭМЯ, ХСҮТ
		ХСҮТ-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эрдэм шинжилгээний баг байгуулж ажиллах							
		Хавдрын чиглэлийн судалгаа, шинжилгээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх							ЭМЯ, ХСҮТ
		Эрдэм шинжилгээний бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх							ЭМЯ, ХСҮТ
7.4 Гадаад харилцааг хөгжүүлэх		Зонхилон тохиолдох зарим төрлийн хорт хавдрын чиглэлээр Азийн орнуудын үндэсний хавдар судлалын байгууллагын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх							ЭМЯ, ХСҮТ
		Зонхилон тохиолдох хорт хавдрын оношлогоо, эмчилгээ, судалгаа шинжилгээний ажлын чиглэлээр Олон улсын байгууллагуудтай хамтран							ЭМЯ, ХСҮТ

		ажиллах							
		Эмч, мэргэжилтэн солилцох чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх							ЭМЯ, ХСҮТ
		Хавдрын чиглэлийн мэргэжлийн ОУ-ын байгууллагуудад гишүүнээр элсэж, үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцох							ЭМЯ, ХСҮТ